



БАЯНХОНГОР АЙМАГ  
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/159

Эмээлтоглой

Галт зэвсгийн үзлэг, тооллого, татвар  
хураалтын ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.10, Хууль зүйн сайдын 2015 оны 10 дугаар сарын 05-ний өдрийн А/220 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Галт зэвсгийн тооллого явуулах журмын 2.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 15-ний өдрийн А/638 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын хэмжээнд галт зэвсгийн үзлэг тооллого, татвар хураалтын ажлыг 2024 оны 11 дүгээр сарын 15-ний өдрөөс 12 дугаар сарын 15-ний өдрийг дуустал хугацаанд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Түмэнжаргал (Засаг даргын орлогч)

Гишүүдэд: Б.Алтангадас (Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн ахмад)

Ш.Ичинхорлоо (Татварын улсын байцаагч)

З.Гантулга (Хэсгийн цагдаа, Цагдаагийн ахлагч)

Ч.Цэдэвсүрэн (1 дүгээр багийн Засаг дарга)

Ж.Должинсүрэн (2 дугаар багийн Засаг дарга)

Б.Гарьдсоном- (3 дугаар багийн Засаг дарга)

Н.Ганжаргал (4 дүгээр багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Амарзаяа (Хэсгийн төлөөлөгч, Цагдаагийн ахлах дэслэгч)

2.Галт зэвсгийн хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, галт зэвсгийн бүртгэл тооллогыг зохион байгуулж, бүртгэлгүй нуугдмал галт зэвсгийг олж илрүүлж, бүртгэлд хамруулан гэрчилгээжүүлэх, галт зэвсгийн бүртгэлд тодотгол хийж бүртгэлийн зөрүүг арилгах, татвар хураалтын ажлыг эрчимжүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч болон гишүүдэд даалгасугай.

3.Галт зэвсгийн үзлэг, тооллого, татвар хураалттай холбоотой гарах зардлыг гаргаж ажиллахыг Санхүү албаны дарга (Д.Азжаргал)-д зөвшөөрсүгэй.

D/2024 on/Zahiramj-2024on-docx

642401343

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Өнөрбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.МӨНХЖАРГАЛ